

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2024.12.10

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Биеийн тамир, спортын салбарын Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2024 оны хагас жилийн хэрэгжилтэд эрх зүйн актын хэрэгжилтэд Монгол улсын тухай хууль, Улсын Их хурлын тогтоол, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлаар санал, зөвлөмж боловсруулах Засгийн газарт хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3 -д аргачлалыг үндэслэн баримтлав. Үүнд:

- “бүрэн хэрэгжсэн” 100 хувь (90-100 хүртэл хувь);
- “хэрэгжих шатанд” 70 хувь (50-90 хүртэл хувь);
- “хэрэгжилт хангалтгүй” 30 хувь (10-50 хүртэл хувь);
- “хэрэгжээгүй” -0 хувь (0-10 хүртэл хувь);
- “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”. үнэлгээг гаргалаа.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

2024 оны хагас жилийн хэрэгжилтэд Биеийн тамир, спортын тухай хууль болон бусад 3 хуулийн 3 заалт, Улсын Их хурлын 5 тогтоол 9 заалт, Улсын Их Хурлын байнгын хорооны 4 тогтоол 13 заалт, Ерөнхийлөгчийн 3 зарлиг 4 заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1 зөвлөмж, Засгийн газрын 4 тогтоол 7 заалт, Засгийн газрын хуралдааны 15 тэмдэглэлийн 18 заалт, Засгийн газрын 3 албан даалгавар 3 заалт нийт 38 шийдвэрийн 58 заалыг хяналтад авч хэрэгжүүлэн ажилласан.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хагас жилийн хэрэгжилт бүрэн хэрэгжсэн буюу “Бүрэн хэрэгжсэн” 100%-ийн хэрэгжилт 43, “Хэрэгжих шатанд” 70 % -ийн хэрэгжилт 11, Хэрэгжилт хангалтгүй 30%-ийн хэрэгжилт 2, Хэрэгжилт байхгүй 2 тус тус үнэлэгдэж хэрэгжилт 91.6 хувьтай хэрэгжсэн байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн нэгдсэн дүн, хүснэгт

№	Үзүүлэлт	Бүгд	Үүнээс							
			Монгол Улсын хууль	Улсын Их Хурлын Тогтоол	Улсын Их Хурлын Байнгын Хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн Зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар
1.	Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	38	3	5	4	3	1	4	15	3
2.	Хяналтад авсан нийт заалтын тоо	58	3	9	13	4	1	7	18	3
3.	Бүрэн хэрэгжсэн 100 хувь (90-100 хүртэл хувь)	43	1	8	8	4	1	6	14	1
	Хэрэгжих шатанд 70 хувь (50-90 хүртэл хувь)	11	2	1	5	-	-	-	2	1
	Хэрэгжилт хангалтгүй 30 хувь (10-50 хүртэл хувь)	2	-	-	-	-	-	1	-	1
	Хэрэгжилт байхгүй.	2	-	-	-	-	-	-	2	-
		91.6	3	9	13	4	1	7	16	3

Гурав: Дүгнэлт

Биеийн тамир, спортын улсын хорооны 2024 хагас жилийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хүрээнд 91.6 хувьтай байна.

Монгол Улсын хууль Үндэсний их баяр наадмын тухай /шинэчилсэн найруулга/ 13.1. Үндэсний их баяр наадмын үндэсний бөх, сурын болон шагайн харваа, үндэсний хурдан морины уяачийн эд хэрэглэл, уралдаанч хүүхдийн хувцас, морины хэрэгсэлд тавигдах стандартыг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага холбогдох үндэсний спортын холбооны саналыг үндэслэн боловсруулж, стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батлах дээр Стандарт хэмжил зүйн газартай хамтарч ажиллахад цаашид анхаарч ажиллах.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн “Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 1.11/. Биеийн тамир, спортын салбарын төрийн өмчлөлд байсан газар, барилга байгууламжийг төрийн өмчид буцаан авах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шуурхай шийдвэрлэх эрчимжүүлж анхаарч ажиллах.

Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2024 оны 02 дугаар сарын 28-ны 2024_77 “Журам батлах тухай” (Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам”)-ын бэлтгэл ажлыг эрчимжүүлж, анхаарч ажиллах шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 19 дугаар тэмдэглэл 2024-05-15 дугаар 2024_19.1 хэлэлцэх багийн бүрэлдэхүүнд манай байгууллагаас оролцоогүй болно.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл 2024-06-06 дугаар 2024_22 хэлэлцэх “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” зөвлөн туслах багийн бүрэлдэхүүнд манай байгууллагаас оролцоогүй болно.

Дөрөв . Санал, зөвлөмж:

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2024 оны хагас жилийн хэрэгжилтийн Монгол Улсын хууль Үндэсний их баяр наадмын тухай, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн “Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай”, Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2024 оны 02 дугаар сарын 28-ны 2024_77 “Журам батлах тухай” хэрэгжилтэд цаашид анхаарч ажиллахыг Төрийн, захиргааны удирдлагын газар, Бодлого төлөвлөлтийн газарт цаашид энэхүү заалт дээр эрчимжүүлж, анхаарч ажиллахыг тус тус зөвлөмж хүргүүлж байна.

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

ХШУДАХ-ИЙН ДАРГА

Н.БАТСҮХ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХШУДАХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

О.БОЛОРМАА